

## МОНГОЛ ХҮҮХДИЙН ЗУСЛАН (2007.07.20 – 07.28)

Индиана мужийн Блүүмингтон хотноо орших Төвдийн Соёлын Төвөөс энэ зун Монгол хүүхдийн зуслан хичээллүүлнэ.

Зуслангийн ажиллах хугацаа:

Ирэх өдөр 7 сарын 20

Хичээллэх өдрүүд 7 сарын 21 – 27

Буцах өдөр 7 сарын 28

Нийт 9 хоног, үүнд бүрэн хөтөлбөр бүхий 7 хоног.

Өглөө бүр Монгол хэл, уран зохиол, ёс заншлын холбогдолтой хичээл заахаас гадна Төвдийн Соёлын Төвийн Тэргүүн Ажаа гэгээнтэн Буддын шажны талаар сургаал айлдана.

Үдээс хойш Монгол бүжиг, дуу заана, мөн Монголын холбогдолтой кино үзнэ.

Оройдоо Индианагийн Их Сургуулийн Монгол судлаач нартай уулзалт хийнэ.

Зуслангийн нарийвчилсан төлөвлөгөөг хамрагдах хүүхдүүдийн эцэг эхчүүдэд илгээнэ.

Зуслангийн төлбөр 180 ам. доллар. Үүнд: хоол, хичээлийн хэрэглэгдэхүүн болон бусад зардлын төлбөр багтсан бөгөөд байр сууц, үйлчилгээг Төвдийн Соёлын Төвөөс үнэгүй гаргаж, Монгол багш нар сайн дураар хичээл заах юм.

Зусланд ирэх буцах замын зардлыг эцэг эхчүүд хариуцна.

Түрүүлж бүртгүүлсэн 20 хүүхдийг зусланд хамруулна. Насны хязгаар 13-17.

**Харилцах утас:**  
**Төвдийн Соёлын Төв 812-330-1249,**  
**Монгол Соёлын Төв 703-933-3771**

Цахим шуудан: [saruulerdene@yahoo.com](mailto:saruulerdene@yahoo.com)  
[saran\\_mongol@yahoo.co.jp](mailto:saran_mongol@yahoo.co.jp)

## Эрхэм хүндэт эцэг, эхчүүд ээ !

Манай зуны сургуульд хүүхдээ явуулахаар шийдсэн танд талархал илэрхийлье.Төвдийн Соёлын Төв, Ажаа Гэгээнтэний санаачилгаар монгол хүүхдүүдэд зориулсан зуны зусланг энэ жил бид анх удаа хамтран зохион байгуулахаар болоод байна. Зусланд хүүхдүүд зөвхөн амрах төдийгүй, нарийн бэлдсэн хуваарийн дагуу хичээл заалгаж, монгол дуу бүжиг суран, Индианагийн Их Сургуулийн монгол судлаач, эрдэмтэн багш нарын яриа лекцийг сонсох болно. Мөн өөр хотоос ирсэн үе тэнгийнхэнтэйгээ уулзан нөхөрлөж, бие биенээсээ ч бас ихийг сурах буй заа.

Ингээд бид танд доорх баримтуудыг илгээж байна. Үүнд:

1. Хүүхдүүдийн авч ирэх зүйлсийн жагсаалт.
2. Зуны сургуулийн ерөнхий хөтөлбөр
3. Өдрийн дэглэм
4. Төвдийн Соёлын Төвийн танилцуулга.
5. Зуны сургуулийн төлбөрийг илгээх хаяг.

Сургалтын төлбөр 180 ам.долларыг та чекээр доорх хаягаар илгээнэ үү.

Tibetan Cultural Center  
<Mongolian Children Summer Camp>  
3725 S.Snoddy Rd  
Bloomington, IN 47401

## Өдрийн дэглэм

7.30	Босох
8:20	Өглөөний хоол
9:00-9:15	Өдрийн төлөвлөгөөг багш нар танилцуулах
9:15-11:00	Сургалтын цаг
11:00-11:15	Цайны цаг
11:15-13:00	Сургалтын цаг
13:00-15.00	Өдрийн хоол, амралтын цаг
15.00-16.00	Монгол дуу, бүжиг сурах цаг
16.00-16.30	Цайны цаг
16.30-19.30	Зочин багшийн яриа, видео кино үзэх Спортын тоглоом тэмцээн
19:30-20.30	Оройн хоол
20.30-22.0	Чөлөөт цаг
22:00	Унтлагын цаг

## Зуны сургуулийн ерөнхий хөтөлбөр

- 7 сарын 20 Хүүхдүүд ирнэ. Хүүхдээ хүргэж ирсэн эцэг эхчүүдэд зориулж Ажаа Гэгээнтэн засал хийж, ном айлдана.
- 7 сарын 21 Сургалт эхлэнэ. Эхний өдөр Монголын тухай ерөнхий танилцуулах хичээл. Газарзүйн байрлал, цаг агаар, соёл, хот хөдөө, монгол хүмүүс ...  
Монгол дуу заах  
Монголын тухай видео үзэх.
- 7 сарын 22 Урд өдрийн үзсэн видеоны талаар санал солилцох, асууж ярилцах.  
Монгол бичгийн хичээл. Ерөнхий ойлголт өгөх, хүүхэд бүр нэрээ бичиж чаддаг болох.  
Уншиж бичиж чаддаг хүүхдэд бол гүнзгийрүүлсэн хичээл өгнө. хөл бөмбөг болон спорт тоглоом.
- 7 сарын 23 Буддийн шашны талаар анхан шатны мэдэгдэхүүн, ерөнхий ойлголт өгөх хичээл. Энэ хичээлийг Ажаа Рэнбүүчи заана.  
хөл бөмбөгийн тэмцээн
- 7 сарын 24 Монгол аман зохиолын хичээл. Үлгэр туульс, оньсого, ертөнцийн гурав...  
Монгол хоолны хичээл  
спорт тоглоом
- 7 сарын 25 Монголын түүхийн хичээл  
Индианагийн Их Сургуультай танилцах экскурс  
Индианагийн Их Сургуулиас зочин багш хүрэлцэн ирж яриа хийнэ. Зөвхөн Монгол судлалаар зогсохгүй АНУ-ын коллеж, их дээд сургуулийн талаар хүүхдүүдийн сонирхсон асуултанд хариулна.

сагсан бөмбөг болон спорт тоглоом

7 сарын 26

Монголын зан заншлын хичээл  
Ярианы урлагын хичээл. Монголоор санаагаа зөв  
цэгцтэй яаж илэрхийлэх  
талаар заана.  
Монгол дуу бүжиг  
Монголын тухай видео үзэх.

7 сарын 27

Үзсэн киноны талаар ярилцах, асуулт хариулт  
Спорт тоглоом, чөлөөт цаг.

Хичээлийг тус сэдвээр дагнан олон жил ажилласан туршлагатай  
багш, эрдмийн зэрэг цолтой эрдэмтэн судлаач нар заах болно.  
Тухайн үеийн байдлаас шалтгаалж хичээлийн агуулга, өдөр цаг,  
багш өөрчлөгдөж болзошгүйг сануулъя.

# Хүүхдүүдийн монгол хэлний мэдлэгийн талаарх асуулга.

1. Хүүхдийн овог, нэр
2. Монголд сургуульд явж байсан эсэх  
Явж байсан бол хэддүгээр анги хүртлээ хэдэн жил Монголд сурсан
3. Монголоор ойлгох чадвар
  - а. чөлөөтэй
  - б. сайн
  - в. дунд зэрэг
  - г. муу
  - д. ерөөсөө ойлгодоггүй
4. Монголоор унших чадвар
  - а. сайн
  - б. дунд зэрэг
  - в. муу
  - г. ерөөсөө уншиж чадахгүй
5. Бичих чадвар
  - а. сайн
  - б. дунд зэрэг
  - в. муу
  - г. ерөөсөө бичиж чадахгүй
6. Монголоор санаагаа илэрхийлж чаддаг эсэх
  - а. сайн
  - б. дунд зэрэг
  - в. муу
  - г. чадахгүй

Эцэг эхчүүдийн зүгээс багш нараас хүсэх зүйл байвал доор бичнэ үү.

# Mongolian Summer Camp 2007

July 20 – 27, 2007

Tibetan Cultural Center

3655 Snoddy Road, Bloomington, IN 47401

Tel: 812-331-0014; fax: 812-334-7046

[www.tibetancc.com](http://www.tibetancc.com); [tcc@tibetancc.com](mailto:tcc@tibetancc.com)

## Registration Form

*Please note that the registration fee for the camp is \$180 which includes all meals, lodging, and local transportation.*

1. Last Name _____	<b>Photo</b>
2. First Name _____	
3. Date of Birth _____	
4. Sex (Male or Female) _____	
5. Father's Name _____	
6. Mother's Name _____	
7. Contact Phone No(s): Home/Work/Cell _____	
8. Contact Address _____	
9. Health Insurance Policy/Health Insurance Company _____	
10. Name of Family Doctor and Phone Number _____	
11. Current Medication (if any) _____	
12. Allergies (if any) _____	

I understand that the Tibetan Cultural Center will take utmost care of my child during the camp. However, if an unforeseen tragedy strikes, I will take full responsibility.

I also authorize the staff of the camp to authorize medical treatment/care to be given to my child if required. I release the Tibetan Cultural Center from any responsibility for any bills incurred from injuries which are not covered under my personal or camp insurance.

Signature of Parent \_\_\_\_\_ Date \_\_\_\_\_